



УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ч.ЧИМЭД

“Увс аймаг Өндөрхангай сумын Чигжийн голд ус хуримтлуулах хөв цөөрөм, далан, боомт”-ын барилгын ажлын зураг төсөв боловсруулах ажлын даалгавар

2024.01.08

Дугаар: ЗТ-01/2017

Улаангом хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл:	-Увс аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр -2024 оны Улсын төсвийн тухай хуулийн VI.1.18 дахь заалт
2.	Барилга байгууламжийн байршил, эдийн засаг нийгмийн хөгжлийн байдал:	Увс аймгийн Өндөрхангай сум Цалуу, Цагаан нуур багийн нутаг дэвсгэрт Чигжийн голын Бор үзүүрт 1. N49°06'50.1" E094°52'06.6" 2. N49°06'50.9" E094°51'56.6"
3.	Зориулалт хүчин чадал:	Ус хуримтлуулах хөв цөөрөм, далан, боомт
4.	Захиалагч байгууллага:	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Увс аймгийн Засаг даргын тамгын газар
5.	Барилга байгууламжийн бүрэлдэхүүн шаардлага, хүчин чадал:	- Ус хуримтлуулах талбай: - Чигжийн гол 321км ²
6.	Технологийн шийдэл:	Зураг төсөл боловсруулах норм дүрэм болон мөрдөгдөж буй холбогдох норм дүрмийг баримтлан сүүлийн үеийн дэвшилтэт шийдлийг сонгох.
7.	Гүйцэтгэх ажлууд:	Эскиз зураг төслийг одоогоор мөрдөгдөж буй норм дүрэм, стандартуудыг баримтлан захиалагчийн хүсэлтийн дагуу боловсруулан батлуулсны дараа ажлын зургийг гүйцэтгэн экспертизээр батлуулж, захиалагчид хүлээлгэн өгөх.
8.	Барилгын үндсэн бүтээц, хийцийн шийдэл:	Дараах байгууламжууд багтана. - Шороон боомт - Эргийн ус хаяур - Хагшаас угаах болон хоослох байгууламж - Ус авах барилга - Ус хуваарилах барилга - Гол болон хуваарилах хоолой /хэрэглэгчдэд ус түгээх/ Далан хөв цөөрмийн барилга байгууламжийн створын дагуу топо зураглал, геологи гидрологийн дүгнэлт боловсруулах - Усан мандлын нуурын талбайд топозураглал хийх

		<ul style="list-style-type: none"> - Ус хуримтлуулах усны хэмжээ 3,5 сая шоо метрээс багагүй байхаар төлөвлөх - Далан, хөв цөөрмийн барилга байгууламжийн хийц зохиомж, дагалдах хийцийн тооцоо, ажлын зураг боловсруулах - Далан, хөв цөөрмийн створт нийлэх гуу жалга, түүний ус хүлээн авах барилга, бэхлэгээний хийцийн зураг боловсруулах - Ус авах барилга, илүүдэл ус хаях барилга хоослох болон угаах байгууламжийг төмөр бетон хийц, бүтээцтэй байхаар төлөвлөх - Боомтын хярын өргөн хэсэгт нэмэлт арга хэмжээ төлөвлөх, явган хүний зам, гүүрэн гарц, хайс хашлага төлөвлөх - Хэрэглэгчдэд ус түгээх гол хоолой юмуу суваг гидрант, хаалт бүхий ус гаргуур төлөвлөнө. - Услагдах талбайд усыг хүргэх ил болон далд хийцтэй гол болон хуваарилах суваг төлөвлөх. - Чигжийн голоос ус зүйн судалгааг хийж, дундаж урсцын ба үерийн хамгийн их 0,01% хангамшилтай урсцын тооцоог хийх. - Боомтын суурийн дагуу газрын доорх усны шүүрэлтийн хэмжилт хийх, коэффициентийг тодорхойлох.
9.	Зураг төсөв зохиох үе шат, хугацаа:	<p>Ус хуримтлуулах далан боомтын барилга байгууламжийн зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний 2 үе шаттай.</p> <ol style="list-style-type: none"> 1. Урьдчилан ТЭЗҮ боловсруулах 2. Ажлын зураг төсөв боловсруулах
10.	Зураг төслийн байгууллага:	Усны барилга байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй, төслийн удирдагч нь зөвлөх инженерийн зэрэгтэй байх, мэргэжлийн дадлага туршлагатай баг хамт олноор хийлгэх
11.	Хөрөнгийн эх үүсвэр:	Улсын төсөв, Зээл гадаадын зээл тусламж
12.	Зураг төсвийн үнэ:	Зураг төсвийн жишиг үнэ: БД81-16-12

13.	Зураг төслийн бүрдэл:	<p>Зураг төсөл боловсруулах бэлтгэл ажил буюу зураг төслийн бүрдэл нь дараах зүйлсийг багтаасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Барилга архитектур -/БА/ - Технологийн байгуулалт -/ТХ/ - Барилга бүтээц /ББ/ - Ерөнхий төлөвлөгөө /ЕТ/ - Инженер геологийн дүгнэлт - Төсөв - Байр зүйн зураглал хийх - Агротехникийн зөвлөмж - Усны барилга байгууламжийн зураглал - Ус зүйн судалгаа, тооцоо - Хөрсний ус-мелиораци, агрохими, агрофизикийн судалгаа тайлан - Магадлалын дүгнэлтүүд - Иж бүрэн магадлал хийгдсэн зураг, төсөв хүлээн авна. - Хэвлэмэл байдлаар 3% - CD байдлаар 3% Захиалагчид хүлээлгэн өгнө. - Ажлын зураг, төсвийг PDF форматаар 300 dpi нягтралтай cd-нд хавсаргах - Ерөнхий төлөвлөгөөг dwg форматаар cd –нд хавсаргах
14.	Онцгой нөхцөл	<p>-Төсөл хэрэгжихтэй холбогдон гарах байгаль орчны болон нийгмийн асуудалд сум орон нутаг, малчид, хөдөлмөрчдийн санал хүсэлтийг тусгаж газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх зардлыг зураг төсөвт тусгасан байна.</p> <p>-Усан сангийн талбай доор орох түүх дурсгалын болон археологийн олдворыг хамгаалах, шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх.</p> <p>-Газар хөдлөлтөөс үүсэх эрсдлийг тооцох.</p> <p>-Байгаль орчны нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийх</p>
15.	Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ:	Estimator pro программаар хийгдсэн байна.

“Увс аймаг Өндөрхангай сумын Чигжийн голд ус хуримтлуулах хөв цөөрөм, далан, боомт”-ын барилгын ажлын зураг төсөв боловсруулах ажлын даалгавар

Хянасан:

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
телевэлэлтийн хэлтсийн дарга

Б.Бат-тогтох

УНТГСГ-ын Захиргааны дарга

М. Анхбаяр

Өндөрхангай сумын Засаг дарга

Г.Төмөрчөдөр

ГХБХБГ-ын дарга

С.Нямжав

ХОХБТХ-ийн мэргэжилтэн

Б.Мөнхбаяр

Б.Мөнхбаяр

Боловсруулсан :

ГХБХБГ-ын БХБХийн дарга

Б.Батболд

УНТГСГ-ын Захиргааны ахлах мэргэжилтэн

Ц.Бат-Эрдэнэ